



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

СЭДЭВ 5: Жендэрийн асуудлууд

Joan McEwen
Long Term Technical Advisor

Яагаад жендэрийг чухалчилдаг вэ?

Эдийн засгийн тогтвортой хөгжил гэдэг нь ихэвчлэн хөгжлийн төслүүдээс гадуур орхигдож үлддэг буюу уурхайгаас үүдэлтэй архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, биеэ үнэлэх зэрэг нийгмийн сөрөг нөлөөллүүдэд илүүтэй өртдөг бүлэг хүмүүст анхаарал хандуулахыг хэлнэ.

Байгалийн нөөц ашиглалт соёл, нийгэм, эдийн засаг болон байгаль орчны олон хүчин зүйлийн орчилд эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралд ихээхэн нөлөө үзүүлдэг.

Жендэрийн тэгш байдлын зөвлөх бүлэг

Уул уурхайн төсөлтэй холбоотой гарч болзошгүй эрсдэл, нөлөөлөл, боломжийг үнэлэх зорилгоор бүх талын оролцогчидтой зөвлөлдсөнөөр төсөл хэрэгжүүлэгчид тухайн төслийн нийгэмд үзүүлж болзошгүй бүхий л нөлөөллийн талаар илүү сайн ойлголттой болох боломжтой.

Уул уурхайгаас хэлэлцүүлэгт жендэрийн тэгш байдлыг хангах төлөөллийн бүлгийг байгуулах нь эмэгтэйчүүд, эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, нэгтгэх, хянах, бусадтай харилцахад чухал ач холбогдолтой юм.

Төлөвлөлтөд анхаарах асуултууд

Үндэсний болон орон нутгийн түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ямар стратеги, бодлогын баримт бичгүүд байдаг вэ?

Жендэрт дүн шинжилгээ хийж, нөлөөллийн судалгаа хийсэн үү?

Уул уурхайн төсөлд нөлөөлөх магадлалтай орон нутгийн буюу бус нутгийн тодорхойлсон тулгамдсан асуудлууд эсвэл хүний эрхийн зөрчсөн ноцтой асуудлууд байдаг уу?

Хүйсээр нь ангилсан ямар нэгэн мэдээлэл байна уу?

Хэлэлцүүлгийн багт эмэгтэйчүүдийг татан оролцуулдаг уу?

Үйл явцад анхаарах асуултууд

Энэ үйл явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөллүүд тэгш оролцдог уу?

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог хумьж болох саад бэрхшээл, хязгаарлалтууд бий юу?

Хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн идэвхтэй оролцоог дэмжиж байна уу?

Олон хүний өмнө чөлөөтэй бодол санаагаа илэрхийлж чаддаггүй хүмүүсийг оролцуулах хэлэлцүүлгийн өөр арга хэлбэр байдаг уу?

Баримтжуулалт болон тайлангийн явцад анхаарах асуултууд

Бүх оролцогчдын үзэл бодлыг тусгасан уу?

Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ хэт нэг талыг барьсан дүгнэлт хийхгүйн тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангасан уу?

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын илэрхийлсэн саналыг үнэн зөвөөр тайланд оруулсан байна уу?

Зөвлөмж хэсэгт жендэр болон соёлын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал оруулсан уу?